| 210401      | Бичиг хэрэг  | 87,800.00             | 191,800.00                  | <b>(104,000.00)</b>    | <b>218.45%</b> |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 441,000.00            | 701,270.00                  | <b>(260,270.00)</b>    | <b>159.02%</b> |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 671,100.00            | 806,800.00                  | <b>(135,700.00)</b>    | <b>120.22%</b> |
| 210404      | Ном, хэвлэл  | 63,800.00             | 63,800.00                   | -                      | <b>100.00%</b> |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 1,839,400.00          | 1,339,400.00                | <b>500,000.00</b>      | <b>72.82%</b>  |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 1,508,000.00          | 1,507,400.00                | <b>600.00</b>          | <b>99.96%</b>  |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | <b>23,131,200.00</b>  | <b>17,451,075.00</b>        | <b>5,680,125.00</b>    | <b>75.44%</b>  |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 476,000.00            | 476,000.00                  | -                      | <b>100.00%</b> |
| 210502      | Хоол, хүнс   | 18,066,300.00         | 12,386,175.00               | <b>5,680,125.00</b>    | <b>68.56%</b>  |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 4,588,900.00          | 4,588,900.00                | -                      | <b>100.00%</b> |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>3,606,900.00</b>   | <b>2,406,870.00</b>         | <b>1,200,030.00</b>    | <b>66.73%</b>  |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 1,200,000.00          | -                           | <b>1,200,000.00</b>    | <b>0.00%</b>   |
| 210604      | Урсгал засвар  | 2,406,900.00          | 2,406,870.00                | <b>30.00</b>           | <b>100.00%</b> |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>89,700.00</b>      | <b>84,000.00</b>            | <b>5,700.00</b>        | <b>93.65%</b>  |
| 210702      | Дотоод албан томилолт  | 89,700.00             | 84,000.00                   | <b>5,700.00</b>        | <b>93.65%</b>  |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>1,309,500.00</b>   | <b>823,500.00</b>           | <b>486,000.00</b>      | <b>62.89%</b>  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 337,500.00            | 337,500.00                  | -                      | <b>100.00%</b> |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 972,000.00            | 486,000.00                  | <b>486,000.00</b>      | <b>50.00%</b>  |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад</b>                                      | <b>1,289,900.00</b>   | <b>1,289,900.00</b>         | <b>-</b>               | <b>100.00%</b> |

|             |   |                       |                       |                        |                |
|-------------|---|-----------------------|-----------------------|------------------------|----------------|
|             | <b>зардал</b>                                       |                       |                       | -                      |                |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                     | 0.00                  | 0.00                  | -                      |                |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                   | 1,289,900.00          | 1,289,900.00          | -                      | 100.00%        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                             | <b>0.00</b>           | <b>23,019,047.00</b>  | <b>(23,019,047.00)</b> |                |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                       | <b>0.00</b>           | <b>0.00</b>           | -                      |                |
| 2135        | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг  | 0.00                  | 23,019,047.00         | (23,019,047.00)        |                |
| 213503      | Төвлөрүүлэх шилжүүлэг                               | 0.00                  | 23,019,047.00         | (23,019,047.00)        |                |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                             | <b>0.00</b>           | <b>1,200,000.00</b>   | <b>(1,200,000.00)</b>  |                |
|             | Дотоод эх үүсвэрээр                                 | 0.00                  | 1,200,000.00          | (1,200,000.00)         |                |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>               | <b>357,609,500.00</b> | <b>356,572,713.00</b> | <b>1,036,787.00</b>    | <b>99.71%</b>  |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                      | <b>319,109,200.00</b> | <b>319,109,200.00</b> | -                      | <b>100.00%</b> |
| 310003      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих            | 319,109,200.00        | 319,109,200.00        | -                      | 100.00%        |
| <b>32</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>               | <b>38,500,300.00</b>  | <b>37,463,513.00</b>  | <b>1,036,787.00</b>    | <b>97.31%</b>  |
| 320001      | Орон нутгийн төсвөөс                                | 38,500,300.00         | 37,463,513.00         | 1,036,787.00           | 97.31%         |
| <b>35</b>   | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>        | <b>0.00</b>           | <b>0.00</b>           | -                      |                |
| <b>37</b>   | <b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>                              | <b>0.00</b>           | <b>0.00</b>           | -                      |                |
| 4           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл    | 0.00                  | 0.00                  | -                      |                |
| 5           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл   | 0.00                  | 0.00                  | -                      |                |
| <b>6</b>    | <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>             | -                     | -                     | -                      |                |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                             | <b>1.00</b>           | <b>1.00</b>           | -                      | <b>100.00%</b> |
| 610001      | Төсвийн байгууллага                                 | 1.00                  | 1.00                  | -                      | 100.00%        |
| <b>22.5</b> | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>                              | <b>22.00</b>          | <b>22.00</b>          | -                      | <b>100.00%</b> |
| 620001      | Удирдах ажилтан                                     | 1.00                  | 1.00                  | -                      | 100.00%        |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан                                   | 7.00                  | 7.00                  | -                      | 100.00%        |
| 620003      | Үйлчлэх ажилтан                                     | 14.00                 | 14.00                 | -                      | 100.00%        |
| <b>63</b>   | <b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>           | <b>124.00</b>         | <b>124.00</b>         | -                      | <b>100.00%</b> |
| <b>65</b>   | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                          | <b>22.00</b>          | <b>22.00</b>          | -                      | <b>100.00%</b> |
| 650004      | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 22.00                 | 22.00                 | -                      | 100.00%        |

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код        | Үзүүлэлт   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл  | Зөрүү дүн    |
|------------|--|------------|------------|--------------|
| <b>II</b>  | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   |            | 114,000.00 | (114,000.00) |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ  |            | 114,000.00 | (114,000.00) |
| <b>210</b> | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   |            | 114,000.00 | (114,000.00) |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил  |            | -          | -            |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл   |            | -          | -            |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал  |            | -          | -            |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал   |            | 114,000.00 | (114,000.00) |
| 210405     | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  |            | 114,000.00 | (114,000.00) |
| <b>I</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  |            | 114,000.00 | (114,000.00) |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого  |            | 114,000.00 | (114,000.00) |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө |            | 114,000.00 | (114,000.00) |
| <b>III</b> | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>  |            |            |              |
| 9          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   |            |            |              |
| 10         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  |            |            |              |

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн /Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримт, анхан шатны баримт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Б.Ундаръяа, аудиторын туслах Б.Сувд-Эрдэнэ нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Бага насны хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад багш, цэцэрлэг, эцэг эх, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулна” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4. Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 386,672.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,866.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,706.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга**

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,885.8 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт          |
|---|------------------|------------------|-------------------|
| Б   | 1                | 2                | 3=2-1             |
| Мөнгөн хөрөнгө                                    |                  |                  |                   |
| Авлага  |                  | 87.6             | 87.6              |
| Бараа материал                                    | 13,578.4         | 17,457.9         | 3,879.5           |
| Үндсэн хөрөнгө                                    | 449,196.9        | 423,344.0        | (25,852.9)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>462,775.3</b> | <b>440,889.5</b> | <b>(21,885.8)</b> |
| Өр төлбөр   |                  |                  |                   |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 462,775.3        | 440,889.5        | (21,885.8)        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>462,775.3</b> | <b>440,889.5</b> | <b>(21,885.8)</b> |

Авлага дансны үлдэгдэл 87.6 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ыг илүү төлснөөс шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 3,879.5 мянган төгрөгөөр өссөн нь Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 271.0 мянган төгрөгийн, Жайка олон улсын байгууллагаас 73.6 мянган төгрөгийн, БСГ-аас 199.3 мянган төгрөгийн ариутгалын бодис, нэг удаагийн хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 23,083.5 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн А/17 тоот тушаалаар 263.0 мянган төгрөгийн бараа материал акталж данснаас хассан, 19,484.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд /анхны өртгөөр/ 1.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас 1,860.0 мянган төгрөгийн ус цэвэршүүлэгч үнэ төлбөргүйгээр шилжин ирж, төсвийн хөрөнгөөр 1,200.0 мянган төгрөгийн хөргүүр худалдан авсан, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 39 дугаар тогтоолоор үлдэх өртөггүй 3,058.3 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 440,889.5 мянган төгрөг болж 21,885.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 30,958.3 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих санхүүжилт буурсан нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,973.6 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн нь түлш халаалтын зардал өссөн нь голлон шалтгаалсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 361,268.5 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа нь танхим болон танхимын бус үйл ажиллагаанд шилжүүлсэнтэй холбоотойгоор төсөвт өөрчлөлт орсон байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр **357,609.5** мянган төгрөгийн төсөв баталснаас 319,109.2 мянган төгрөгийг улсын төсвөөс *тусгай зориулалтын шилжүүлгээр*, 38,500.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 319,109.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 37,463.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 356,572.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 333,553.7 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 23,019.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **333,553.7** мянган төгрөг буюу 93.3 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ийн зардал 16,852.9 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 5,680.1 мянган төгрөгөөр, аудит баталгаажуулалтын зардал 486.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгал халдваргүйжүүлэлт 114.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**3.7.1** Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх,*

туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгосон байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

**3.7.2** БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын нэгдүгээр хавсралт “Короновируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 147 мэдээллийг бүрэн оруулсан, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгт 357,609.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 333,553.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 6.7 хувиар хэмнэж Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

---

Аудитаар нийт 13,291.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 308.2 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 397.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 акт тогтоон, 12,586.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд ХХОАТ-ын авлага 87.6 мянган төгрөгийг тусгаагүй, ХХОАТ-ын тайланд тайланд оны татварыг 166.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, цалингийн зардалд 54.0 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал оруулан тайлагнасныг тус тус залруулав.

### 4.2 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан цагийн бүртгэлээр баталгаажуулаагүй байхад эрхлэгч С.Оюунчимэгт 279.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон илүү цагийн хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. Нягтлан бодогч Ц.Ундраад хавсран гүйцэтгэж буй цалинг үндэслэлгүй нэмж 117.4 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13

дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

#### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

##### **1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд**

**1.1.1 Илрүүлэлт**: Тайлант онд 12,386.2 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

**1.1.2 Өгсөн зөвлөмж**: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх

##### **1.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал**

**1.2.1 Илрүүлэлт**: Албан томилолтын хуудсыг хаалгаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан бичигдээгүй, унаа байрны зардлын баримтгүйгээр албан томилолтын зардалд 200.0 мянган төгрөг олгосон байна.

**1.2.2 Өгсөн зөвлөмж**: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт “төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын заалтуудыг зөрчиж байгаа тул анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг бүртгэж байх.

##### **1.3 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал**

**1.3.1 Илрүүлэлт** Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

**1.3.2 Өгсөн зөвлөмж:** Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3 дахь заалтуудыг зөрчсөн байгаа тул холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |          | Үүнээс    |       |               |       |                 |     |         |          |
|-----|-------------------------------------|----------------------|----------|-----------|-------|---------------|-------|-----------------|-----|---------|----------|
|     |                                     |                      |          | Залруулга |       | Төлбөрийн акт |       | Албан шаардлага |     | Зөвлөмж |          |
|     |                                     | Тоо                  | Дүн      | Тоо       | Дүн   | Тоо           | Дүн   | Тоо             | Дүн | Тоо     | Дүн      |
| 1   | Жавхлант сумын нэг дүгээр цэцэрлэг  | 7                    | 13,291.4 | 3         | 308.2 | 1             | 397.0 |                 |     | 3       | 12,586.2 |

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.